


















ЗОНХИЛОХ МОД, СӨӨГНИЙ ҮР ТҮҮХ, ТАРИЛТАНД БЭЛТГЭХ, ТАРИХ ХУГАЦАА



 Мод, сөөгний нэр, тархалт	Мод, сөөгний биологийн онцлог	Цэцэг-лэх хугацаа (сар)	Үр түүх хугацаа (сар)	Их үрийн жилийн давтагдал	1000 үрийн дундаж жин (гр)	Үр хадгалах хугацаа, жил (Савангийн дагуу хадгалахын хугацаа)	Үрийг тарилтанд бэлтгэх арга	Үр тарих хугацаа	Үрийн зэрэг	Соёлолт, %	Амьдрах чадвар, %	1 уртааш м-т (5 см өргөн) тарих үрийн норм, гр	Үр тарих гүн, см	
 Эгэл нарс <i>Pinus sylvestris</i> L. Сосна обыкновенная Голын хөндийн элсэнцэр газар, уулын чулуурхаг болон хээржүү хажууд ургана. - Хөвс., Хэнт., Ханг. (зүүн хойт: Сэлэнгийн хөндий), Монг-Даг., Хянг. (Халхын гол), дунд халх (Бор өндөр уул), Дорн-Монг. (Халхын голын зүүн эрэг)	20-45 м хүртэл өндөр ургадаг. Нимгэн хальслаг холтостой, холтос нь оройруугаа дээшлэх тусам нимгэрч улаан шар өнгөтэй болдог. Шилмүүсний урт 5-10 см, нэг нахианаас хоёр шилмүүс гардаг. Үрийн болц гүйцэх үед боргоцойны өнгө хүрвэртэр болох ба урт нь 2,5-7,6 см, өргөн нь 2-3 см болно. Боргоцой нь 2-р сарын сүүл 3 сард бүрэн боловсорч танилж үрээ гевнэ. Үрээ гэвсэн боргоцой удаан хугацаанд ишиндээ хадгалагддаг онцлогтой. Эгэл нарсны үр цайвар хүрэн, гялалзсан хүрэн, хар хүрэн өнгөтэй том далавчтай, өндгөн буюу зууван хэлбэртэй байна.	Y-YI	X-III	3-5	7.0	4-5	30-60 хоног цаслах, 1-2 хоног цасны усанд дэвтээх	Y/II арав хоног X	I II III	90 80 60	90 80 60	1.5-2.0	1.0-2.0	
 Сибирь хуш <i>Pinus sibirica</i> Du Tour. Сосна сибирская кедровая Уулын шинэсэн ой, ойн дээд захаар зонхилдог. -Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Алт. (баруун хойт: Ахсу гол, Ховдын дээд нуур)	20-25 м хүртэл өндөр ургадаг. Бор саарал холтостой, сагалаар өргөн титэмтэй, нэг нахианаас таваар баглан гарсан 6-13 см урт нягт ногоовтор өнгийн шилмүүстэй. Шилмүүсээ 3-6 жилд сольж гүвнэ. Боргоцой нь 6-12 см урт, 30-40 хайрстай, самар нь 8-14 мм урт, яслэг ба хальсан бүрхүүлээс тогтоно.	Y-YI	IX-XI	4-5	217.0	1-2	Идэвхжүүлэгч бүхий усмалд 3-4 өдөр дэвтээгээд элс буюу үртэстэй хайрцаганд хийж цасан дор 70-90 хоног байлгана	IX/III арав хоног-X/II арав хоног, Y/I арав хоног	I II III	- 85 70	85 70 50	25.0	1.0-3.0	
 Сибирь шинэс <i>Larix sibirica</i> Ldb. Лиственница сибирская Уулын ойн зонхилох мод, хааяа голын хөндий, уулын доод бүс. - Хөвс., Хэнт., Ханг., Монг-Даг., Ховд, Монг.-Алт., Их н. (Улаангом), Зүүн гар. (Байтаг-Богдын нуруу)	30-40 м өндөр ургадаг. Нас гүйцсэн модны холтос гүн чуурсан гадуураа хар саарал, дотроо улаан хүрэн өнгөтэй байна. Шилмүүс нь зөөлөн, цайвар ногоон өнгөтэй, намар шарлаж унадаг. Боргоцой нь 2-3 см урт, өндгөн буюу гонзгойдуу зууван хэлбэртэй байна. Үрийн нэг хайрсанд 2-5 мм урттай далавч бүхий үр байрлана. Үрийн нэг тал бараан толбо бүхий шар өнгөтэй, нөгөө далавчтай тал нь гялгар байна.	Y-YI	YIII-IX	3-5	5.0	4-5	1-2 хоног усанд дэвтээгээд 30-60 хоног цаслах	IX/ III арав хоног -X/ I арав хоног Y/ I арав хоног	I II III	70 55 40	70 55 40	3.5	1.0-2.0	
 Сибирь гацуур <i>Picea obovate</i> Ldb. Ель сибирская Тайган ойд ихэвчлэн ойн бүслүүрийн дээд хэсгээр, нураг асгараг, хавцлын эхээр. –Хөвс., Хэнт. (төв; Богд уул; Зүүн мод), Ханг.(баруун хойно; Тэсийн голын хөндий), Монг.-Алт. (Ховд голын эх)	40 м хүртэл өндөр ургадаг мөнх ногоон мод. Бараан саарал холтостой, зурвас нарийн ан цавтай, сууриасаа эхэлсэн хурц шовгор цацархуу титэмтэй, нэг нахианаас нэг шилмүүс гардаг ба шилмүүс нь хар ногоон гялалзсан өнгөтэй, 2-3 см урт, боргоцой нь 6-7 см урт, улаавтар буюу цайвар бор өнгөтэй өндөг хэлбэртэй. Шоох үзүүртэй, өндгөн хэлбэрийн жигд хүрвэртэр өнгөтэй 3-5 мм урт үртэй.	Y-YI	YIII-IX	3-4	5.0	3-4	KMnO ₄ -ийн 0.05%-ийн усмалд 2 цаг дэвтээгээд 30-45 хоног цаслах	Y-YI	I II III	80 65 50	80 65 50	2.5	0.5-1.5	
 Сибирь жодоо <i>Abies sibirica</i> Ldb. Пихта сибирская Тайган ойн ам хавцалын ёроол, ойн бүсийн дээд хэсгээр (хэвтээ байдлаар) тохиолдоно. -Хэнт. (Хүдэр голын эхээр)	30 м хүртэл өндөр ургадаг мөнх ногоон шилмүүст мод. Хүрвэртэр бараан саарал өнгийн, гялгар гадаргуутай нимгэн холтостой. Гөлгөр бараан саарал холтостой, нарийхан шовгор титэмтэй, анхилуун үнэрт давирхайлаг мод. 2-3 см урт мохоо дээд тал нь хар ногоон өнгөтэй, доод талдаа цайвар хоёр судалтай, хавтгайтар зөөлөн шилмүүстэй. Боргоцой нь 5-9 см урт, 2-4 см өргөнтэй, болц гүйцсэн үедээ цайвар бор өнгөтэй, мухар оройтой, гадуураа давирхайтсан.	Y	YIII-IX	3-4	6.0-11.0	2	1-2 хоног усанд дэвтээгээд 30-60 хоног цаслах	Y, IX, X	I II III	65 55 40	- - -	6.0	1.0-2.0	
 Жижиг навчит хайлас <i>Ulmus pumila</i> L. Вяз приземистый Уулын хад, чулуурхаг хажуу, ам хөндий, сайрын зах, оёор, горхи, булгийн зах, голын хөндийн элс, чулуурхаг хажуу, элсэрхэг сийрэг нарсан ойд. -Хөвс (баруун), Хэнт., Ханг., Монг.-Даг.,Монг.-Алт (баруун хойт), Дунд Халх, Дорн-Монг., Дорн-говь., Говь-Алтай, Алаш	5-10 м хүртэл өндөр ургадаг нарийхан нүцгэн найлзууртай, шаргал саарал холтостой. Залуу мөчир, найлзуур нь шар холтостой, навчны нахиа мохоо өндгөрхүү. Далавчит үр жимс нь зууван юм уу дугуй, голчоороо 0.5-1 см, үр нь түүнийхээ гол дунд товойж байрладаг.	IY-Y	Y-YI	Жил бүр	5.6-6.0	1	4-5 цаг усанд дэвтээгээд шууд тарих	Y/ III арав хоног -Y/ I арав хоног	I II III	65 55 40	- - -	2.0	0.5-1.0 (Далд-лах төдий)	
 Лаварнавчит улиас <i>Populus laurifolia</i> Ldb. Тополь лавровлистный Өндөр уулын бүслүүр хүртэлх голын чулуурхаг эрэг, эрэг орчмын элс, хайрга, голын эргийн ой, ам хөндийн хажуу, оёор, хавцалд. –Хэнт., Ханг. (төв), Ховд, Монг.-Алт., Их н., Говь-Алт. (Зүүн Сайхан), Зүүнгар	10-15 м хүртэл өндөр ургадаг. Саарал холтостой, залуу найлзуурууд ирмэгтэй, сааралдуу шар өнгөтэй. Өргөн шаантархуу суурьтай зууван хэлбэрийн ногоон анхилуун үнэрт навчистай. Цилиндр хэлбэрийн эзэмэг цэцэгтэй, үр нь жижиг, хар хүрэн өнгөтэй ба багц үснэцэртэй байдаг.	IY-Y	YI	1-2	0.7-0.8	-	Түүгээд шууд тарина.	Үрийг түүсэн даруй, тайраадсыг IX-X, IV-Y саруудад	-		Бортгонд		0.2	
 Яшилдуу цацаргана <i>Hippophae rhamnoides</i> L. Обленхия крушиновидная Гол, нуурын эрэг, хөвөө, голын дагуух ой, ойн зах, эргийн хайрга, ам хавцлын хажууд. –Ханг. (Улиастай орчим), Монг.-Даг. (Сэлэнгэ мөрний дунд үе), Ховд. (Бөх-мөрөн гол), Монг.-Алт. (Хасагт хайрхан; Булан голын эх), Их н. (Үвс нуур), Олон н. (Бэгэр нуур), Говь-алт. (Их Богд уул)	1.5-5 м хүртэл өндөр сөөг. Богиноссон мөчрүүд нь өргөсөөр төгссөн, иш, мөчрийн холтос хүрэн бор, залуу үедээ мөнгөлөг цайвар байгаад аажмаар бор саарал болдог. Навчны өнгөн тал бор ногоон, доод тал шарвартаг юм уу цайвар өнгийн хайрслал үснэцэртэй. Жимс нь 0.8-1 см урт, 0.3-0.6 см голчтой улаан шаргал, шар өнгөтэй анхилан үнэртэй, чихэрлэг, шүүслэг, исэлэн байна. Үр нь өндгөн хэлбэртэй, цайвар хүрэн гялалзсан хар өнгөтэй.	IY-Y	YIII-XII	1-2	9.0-12.0	2	Хавар тарих үрийг тарихаас 1-2 сарын өмнө толилогдон уунд том ширхэгтэй элстэй 1.3 хэрцүүлж хольж усан 18-20°C хэм гэдэг байгаж 7 хоногт 1-2 удаа хутган үр хөөж, соёлыг эхлүүлж мөхтэй байранд 0.5 миний нөхцөлд чихэрлэг байлганд тарихын өмнө сэрвэж аруулгана.	Жимснээс ялгаж авсан даруйдаа тарьж болно. Намар газар хөлдөхөөс өмнө, хавар эрт тарина.	I II III	90 75 60	- - -	3.5	1.0-2.0	
 Өргөст нохойн хошуу <i>Rosa acicularis</i> Lindl. Роза игольчатая Ойн болон өндөр уулын бүслүүрт шинэсэн ба нарсан ой, хусан төгөл, ойн зах, эргийн сөөгөн дунд, эргийн ой, хад асга, нураг, чулуун дүнд. -Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Дунд. Халх., Дорн-Монг., Говь-Алт. (Гурван Богд, Гурван сайхан)	2 м хүртэл өндөр ургадаг, туйхан иштэй сөөг. Иш мөчир, найлзуур, навчны бариул нь хүртэл өргөслөг. Навч нь сондгой өдлөг цайвар ногоон өнгөтэй. Голчоороо 3-6 см ягаан, хүрэн, улаан өнгийн 5-7 дэлбээ бүхий цэцэгтэй. Улаан шаргал, улаан ягаан, хүрэн өнгийн бөөрөнхийтөр юм уу, нэг тал руугаа нарийссан зууван жимстэй, жимс нь дотроо үсэрхэг орой бүхий бөөрөнхий үртэй.	YI /9- YI/24	IX-X	Жил бүр	12.0	-	Үрийг түүгээд шууд усанд 60% хүртэл чийгтэй байхаар дэвтээгээд 210 хоног элслэх.	YII/ III арав хоног -IX/ II арав хоног	I II III	- - -	85 65 50	3.0-3.5	1.0-2.0	
 Үхрийн нүд <i>Ribes nigrum</i> L. Смородина чёрная Шинэсэн ой, ойн зах, голын эргээр. –Хөвс., Хэнт., Ханг., Хянг., Ховд., Их н. (Улаангом орчим), Говь-Алт. (Зүүн Сайхан)	1-1.5 м өндөр ургадаг сөөг, цагаан өнгийн цэцэгтэй. Навчны өвөр тал нь нүцгэн, ар тал нь судлаа дагаад үслэг, цайвардуу ногоон өнгөтэй.	Y-YI	YII-YIII	5-7 насандаа	2.0	1-2	Чийгтэй байхаар усанд дэвтээгээд 80 -90 хоног элслэх/цаслах	IX/ III арав хоног -X/ II арав хоног, хавар нахиа хөөж задраагүй үед	I II III	- - 60	95 80 60	0.5	1.0	
 Сибирь тэс <i>Sorbus sibirica</i> Hedl. Рябина сибирская Ойн дээд зах, ойт тундрт. –Хэнт., Монг.-Даг. (Ноён уул)	Саарал холтостой, 3-15 м хүртэл өндөр ургадаг. Бүх гадаргуугаараа жигдээр сийрэг байрласан, нарийхан үсээр бүрхмэл буюу нүцгэн нахитай. Гонзгойдуу, юлдэн хэлбэрийн навчны ар тал нь гялгар гадаргуутай, ногоон өнгөтэй, өвөр тал нь саарал ногоон өнгөтэй. Цагаан өнгийн дэлбээтэй баг цэцгийн урт 6-8 см, өргөн 8-12 см байна.	Y-VI	IX-X	1-2	3.6	1-2	Үрийг түүгээд шууд 60% хүртэл чийгтэй байхаар усанд дэвтээгээд 130-200 хоног элслэх	Хавар, намар	I II III	- - -	90 85 55	1.8-2.0	1.0-2.0	
 Сибирь гүйлс <i>Armeniaca sibirica</i> L. Абрикос сибирский Хотгор хөндийн хажуу, хээрийн сөөгөн шугуй, хээрийн хад цохиот болон чулуурхаг хажуу, хад асганд. -Хэнт. (Баянголын хөндий), Ханг. (зүүн хойт), Монг.-Даг., Хянг., Дорн-Монг. (Халхын гол, Авдарын гол, Баруун Хан уул)	2 м хүртэл өндөр ургадаг, улаавтар хүрэн холтостой, зүг бүр тийшээ салаалан ургасан олон мөчиртэй. Цэцэг нь ягаан, цайвар ягаан судал бүхий цагаан дэлбээтэй, 1.2-2.5 см урт, өргөнтэй шар юмуу улаан шаргал өнгөтэй дотроо ясархаг үртэй гашуун амттай, 2.5-3 мм зузаан идээтэй үсэрхэг жимстэй.	Y/21- YI/2	YIII-IX	Жил бүр	1400.0	2-3	48 цаг усанд дэвтээгээд 30 хоног цаслах	Y-YI IX, X	I II III	- - 80	95 90 80	30.0-40.0	2.0-4.0	
 Өрөл <i>Malus baccata</i> L. Яблоня ягодная Ой болон ойт хээрийн бүслүүрт нарсан ой, хусан төгөл, уулын энгэрийн хөмгий, жалга даган ургана. - Хэнт., Ханг. (Хойт Тамирын эх), Монг.-Даг., Хянг.	5 м өндөр ургадаг мод. Бараан сааралдуу холтостой. Цагаан, цайвар ягаан өнгийн цэцэг нь 4-8-аар нийлж байрласан шүхэр баг цэцэгтэй. Үр жимс нь урт шилбэтэй, шар буюу улаавтар өнгөтэй. Цэцэг нь ойролцоогоор 0.6-0.8 см голчтой.	YI/2- YI/17	IX-X	Жил бүр	26.0	1-2	Чийгтэй байхаар дэвтээгээд 100 хоног цаслах	X	I II III	- - 65	90 80 65	1.5-2.0	0.6	
 Хавтаг навчит хус <i>Betula platyphylla</i> Sukacz. Берёза плосколистная Ойн болон ойт хээрийн бүслүүр дэх ам хавцал, голын хөндий, уулын хажуу, бэлээр ой үүсгэдэг, мөн шинэс, хуш-шинэсэн ой, нарсан ойд ургадаг. - Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Ханг.	Цагаан холтостой 10-15 м өндөр ургадаг, мөчир нь гөлгөр. Навчис 5-7 хос хажуугийн судалтай. Жимслэх молцогийн цэцгийн дагавар хайрс бадриун, урт суурьтай. Үр нь далавчтай, шаргал өнгөтэй.	IY-Y	YII-YIII	1-2	0.1-0.4	1-2	6 цаг усанд дэвтээгээд 30-45 хоног цаслах/элслэх	IX/ III арав хоног -X/ II арав хоног, хавар нахиа хөөж задраагүй үед	I II III	55 35 25	- - -	2.5-3.5	0.2	
 Час улаан долоогоно <i>Crataegus sanguinea</i> Pall. Боярышник кроваво-красный Голын хөндий, хусан төгөл, задгай ам, ойн захаар. -Хэнт. (баруун), Ханг. (Эгийн гол), Монг.-Даг., Дорн-Монг. (дорнод)	1-3 м өндөр, өргөс хатгууртай сөөг. Навчис өргөн тонгоруу өндгөрхүү, 2 -6 см урт, 2.5-5 см өргөн, 3-7 бяцхан салбан юмуу шүдтэй, тархай үсэрхэг. Цэцэг нь цагаан өнгөтэй, бөөрөнхийтөр, голчоороо 10 орчим мм, улаан өнгөтэй, дотроо үсэрхэг бүрхүүл бүхий 3-4 үртэй яст жимсгэнэтэй.	YI/5- YI/17	YIII-IX	Жил бүр	27.0	2-3	Үрийг түүгээд шууд 60% хүртэл чийгтэй байхаар усанд дэвтээгээд 160-240 хоног элслэх	IX, X	I II III	- - 55	85 70 55	7.0-8.0	2.0-4.0	
 Хар үрт чаргай <i>Cotoneaster melanocarpa</i> Lodd. Кизильник черноплодный Хээрийн чулуурхаг ба хадтай хажуу, хотос хонхор, хажуугийн сөөгөн шугуй, хусан төгөл, шинэсэн ой, нарсан ой, ойн захаар. –Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Ховд., Монг.-Алт., Дунд. Халх., Дорн-Монг., Их н. (Зүүн Жаргалантын нуруу), Говь-Алт. (Гурван Богд, Гурван Сайхан)	1-2 м өндөр ургадаг сөөг. Нэг настай найлзуур нь гялгар гадаргуутай, улаан өнгөтэй, өндгөн буюу зууван хэлбэрийн, навчны үзүүр нь хурц, мохоо, ухалтай, цэцэг нь цагаан, ягаан өнгөтэй. Цэцэг нь 5-15 араа навчны өврийн цацаг юм уу бамбайрхуу залаанд байрладаг. Жимс нь хар, саарал өнгөртэй.	Y/26- YI/9	YIII-IX	1-2	13.0	1-2	Чийгтэй байхаар дэвтээгээд 100 хоног цаслах	IV, IX, X	I II III	- - 60	90 75 60	3.5-4.0	2.0-3.0	
 Шар хуяйс <i>Caragana arborescens</i> Lam. Жёлтая акация Ойн бүслүүрт шинэсэн ой, түүний зах, хад чулууны дэргэд юм уу чулуурхаг хажуу, голын эрэг дагаж ургана. –Хотын ногоон байгууламж, хотын чимэглэлд., Хөвс., Ханг.	2-5 м хүртэл өндөр ургадаг моджуу сөөг. Ногоовтор юм уу боровтор зөөлөн найлзууртай, 4-7 хос өдлөг нийлмэл навчтай. Дэлбээ нь цоморлигоосоо бараг 3 дахин урт, шар өнгөтэй, буурагч нь бортондуу, дотроо 3-7 ш үртэй. Тод шар өнгийн цэцэгтэй.	YI/1- YI/3	YII-YIII	1-2	28.0	3-4	1-2 хоног усанд дэвтээж 30 хоног цаслах	Y	I II III	90 75 55	- - -	3.5-4.0	1.0-3.0	
 Азийн монос <i>Padus asiatica</i> Kom. Черёмуха азиатская Голын хөндий, эргийн дагуух ой, горхийн эрэг, хусан төгөл, уулын амны хажуу, оёорт. - Хэнт., Ханг., Монг.-Даг. (өрөнд, дорнод), Хянг., Дорн-Монг. (Халхын гол)	Өтгөн титэмтэй, намхан юм уу бэсрэг мод, жилийн найлзуур нь хилэнлэг, үсэрхэг, мөчир дээрээ мэдэгдэх төдий бэрүүстэй. Навчис нь зуувар юм уу тонгоруу өндгөрхүү, богино шовх үзүүртэй, залуу навчис саарал өнгөртэй, доод талдаа үсэрхэг юмуу судлын өвөрт шаргалдуу багц үстэй. Цэцэг нь цагаан өнгөтэй тав таваараа багцалж байрладаг.Цацаг багц үстэй 10-15см урт.	Y/20- YI/10	YIII-IX	Жил бүр	55.0	2	Үрийг түүгээд шууд 60% хүртэл чийгтэй байхаар дэвтээгээд 120-150 хоног цаслах/элслэх	Хавар, намар	I II III	- - 60	90 70 60	6.0-7.0	1.0-4.0	
 Гурван дохиурт бургас <i>Salix triandra</i> L. Ива трёхтычинокая Хөвс., Монг.-Даг. (Ерөө голын адаг)-ын тойрогт голын эргээр ургана.	Цайвар саарал холтостой 4-5 м хүртэл өндөр ургадаг сөөг. Навч нь ихэвчлэн цувж байрлах боловч хааяа хосоор чатгалж байрладаг. Баг цэцэг нь түрүү маягийн эзэмг бөгөөд цэцгийн дагавар нь урт цагаан үстэй, дохиур 3, үрэвч болон хонгорцог урт шилбэтэй (1-2 мм).	IY-Y	Y-YI	Жил бүр	0.1-0.3	9-11 сар	3-4 цаг дэвтээж шууд тарина.	Тайраадаасар үржүүлэхдээ хавар 4-р сарын сүүлчийн 10 хоногоос 5-р сарын сүүлч хүртэл, намар 10-р сарын 1-нээс 15-ны хооронд суулгана. Энхээ хоорондоо 70-80 см байна.					1.0	0.2
 Алтайн далан хальс <i>Lonicera altaica</i> Pall. Жимолость алтайская Ой болон өндөр уулын бүслүүрийн доод хэсгээр шинэсэн ба хуш-шинэсэн ой, тэдгээрийн зах, хад цохио, чулуун асгараг, нураг, сөөгөн шугуйд. -Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Ховд., Монг.-Алт., Их.н. (Зүүн Жаргалантын нуруу), Говь-Алт. (Гурван Сайхан).	1.2 м хүртэл өндөр ургадаг сөөг. Хуурч салбарсан саарал хүрэн өнгийн холтостой, шаантархуу буюу дугуй суурьтай, мухар үзүүртэй, гонзгойватор зууван хэлбэрийн навчны хоёр тал нь нүцгэн ба навчны угт хосоор байрласан цагаан шаргал цэцэгтэй.	Y-YI	YII-VIII	Жил бүр	5.0	1-2	Чийгтэй байхаар дэвтээгээд 60-90 хоног цаслах/элслэх	Y	I II III	- - 60	90 85 60	0.5-1.0	1.0	
 Тоорой <i>Populus raznolistnyy</i> Schrenk. Тополь разнолиственный Говь цөлийн бүсийн уулын ам хавцал, хөндийн цайр элсэн манханд голлон ургадаг. Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алшаагийн говь, Дорноговийн тойрогт тархан ургана.	Гол иш нь ихэвчлэн 2-4 м хүртэл эгц шулуун гувартай байх ба түүнээс дээш болохоор 1-4 салаалж, шүхэр хэлбэрийн титэм үүсгэнэ. Эр цэцэг нь боровтор, дотроо ногоон өнгөтэй, зууван хэлбэртэй. Эм цэцэг нь дэлбээлж буй цэцгэн хэлбэртэй. Эм цэцгийн зууван хэлбэр бүхий нэг бортгонд 6-10 ш үр байна. Заримдаа 20 ширхэг хүрэх тохиолдол ч бий.	IY-Y	YI	сарын эхээр (YII - Алтайн өмнөд)	0.1	Түүснээс хойш 24 цагт тарина.	Бүлээн усанд 1 цаг дэвтээгээд аруулгаж цэвэрлэсэн үрийг том ширхэгтэй элстэй 3:1-ийн хэмжээтэй хольж тарина.	YI/ II арав хоног -YI/ III арав хоног	I II III	- - -	-	Нэг уртааш м-т 4 мөрөөр 3 см-ийн өргөн талбайд 0.3 гр үр тарина.	0.5	
 Зар <i>Haloxylon ammodendron</i> C.A.Mey. Саксаул замканский Нүүний, тогтворгүй ба тогтвортой элс, хужирлаг элс ба марц, нам дор газрын марилэг ёроол, тойром, хуурай хавцал ба том сайрын элсэрхэг ёроол, сондуул, шугуй, нимгэн давхраат элс, шаварлаг-бүтэрэмхий чулуулалт хурдас, гуравдагч сархиаг газар ургана. –Их.н (Хяргас нуур ба Хар ус нуурын хоорондох хөндий ба өмнөд хэсэг), Олон н., Дорн-Говь, Говь-Алт., Алт.-өөр, Зүүнгар., Алаш.	Цагаавтар саарал холтостой, олон салаалж мөчирлөсөн, дунджаар 2-3 м өндөртэй, сөөг хэлбэрээр ургана. Загийн иш муруй тахир ургах ба модлог хатуу. Иш, мөчир нь цагаан саарал өнгийн нимгэн хальсаар хучигдана. Навчис ойт байхгүй юмуу найлзуурын үеийн ирмэгээр маш богинохон төвгөр үлдвэртэй. Үр нь дугуй хэлбэрийн 5 далавчны гол дунд байрлах 2 мм хэмжээтэй хөврөлөөс бүрдэнэ.	IY-Y	IX-X	Жил бүр	2.0-4.0	2	Шууд тарина	Цөлийн бусад: Y/ I арав хоног -Y/ I арав хоног Цөлөрхөг хээрийн бусад: Y/ I арав хоног -Y/ I арав хоног	I II III	70 60 50	- - -	3.0	0.5-1.0	
 Муркрофтын жигд <i>Eleagnus Moegroffii</i> Wall. Лох Муркрофта Байгаль дээр Алашаагийн говийн Хөвдийн баянбүрд, Алтайн өвөр говийн Эхэн-зулганайн баянбүрдэд ургана.	6-8 м орчим өндөр сөөг, бор холтостой, ихэвчлэн хурц өргөстэй буюу зарим тохиолдолд өргөсгүйгээр ургадаг. Мөнгөлөг цайвар өнгийн хайрслал навчтай, ишний доод хэсэгт байрласан навч зууван дугуй дээд хэсгийнх нь юлдэрхүү хэлбэртэй. Үр жимсийн га													